



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Раднаа овогтой Ариунбилэгийг 2003-2004 оны хичээлийн жилээс Австрали улсын Монаш Их сургуулийн магистрантурт байгаль орчны шинжилгээний чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 323 дугаар тушаалын Раднаа овогтой Ариунбилэгтэй холбоотой хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2003-323- Тушаал кодификаци хийгдсэн

САЙД-г

А.ЦАНЖИД